

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ-329

ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

329.1. Зорилго	2
329.3. Тодорхойлолт.....	2
329.5. Дүрмийн үйлчлэх хүрээ.....	2
329.7. Тээвэрлэлтийн гэрээ.....	2
329.9. Тээвэрлэгчийн үүрэг.....	2
329.11. Тээвэрлэлтийн гэрээний нөхцөл	2
329.13. Тээвэрлэлтийн нөхцөлийн талаар мэдэгдэх	3
329.15. Хязгаарлалт.....	3

Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын
2010 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 160 дугаар
тушаалын 23 дугаар хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ- 329 ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

329.1 Зорилго

(а) Агаарын тээвэрлэгч (цаашид Тээвэрлэгч гэх)-ийн үйлдэх олон улсын болон орон нутгийн хуваарьт нислэгийн тээвэрлэлтийн гэрээнд тавигдах шаардлагыг тогтооход энэ дүрмийн зорилго оршино.

329.3 Тодорхойлолт

Агаарын тээвэрлэгч гэж ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн аж ахуйн нэгж, байгууллагыг;

Зорчигч гэж агаарын хөлгөөр зорчихоор тээвэрлэгчтэй гэрээ байгуулсан этгээдийг тус тус хэлнэ.

329.5 Дүрмийн үйлчлэх хүрээ

(а) Энэ дүрэм нь, Монгол Улсад бүртгэлтэй Тээвэрлэгчийн гүйцэтгэх орон нутгийн болон олон улсын тогтмол нислэгийн тээвэрлэлтийн гэрээнд хамаарна.

329.7 Тээвэрлэлтийн гэрээ

(а) Зорчигч тээвэрлэх гэрээгээр тээвэрлэгч нь зорчигч, түүний тээшийг гэрээнд заасны дагуу тээвэрлэх, гэрээнд өөрөөр заагаагүй бол зорчигч нь тээвэрлэлтийн хөлсийг төлөх үүргийг тус тус хүлээнэ. Зорчигч тээвэрлэх гэрээний баримт нь зорчигчийн тийз, тээш тээвэрлэх баримт нь тээшний зүүлт байна.

(б) Ачаа тээвэрлэлтийн гэрээгээр Тээвэрлэгч нь ачаа илгээгчийн ачааг гэрээнд заасны дагуу тээвэрлэх, гэрээнд өөрөөр заагаагүй бол илгээгч нь ачаа тээвэрлүүлсний хөлсийг тогтоосон тарифын дагуу төлөх үүргийг тус тус хүлээнэ. Ачаа тээвэрлэх гэрээний баримт нь ачааны дагавар бичиг байна.

329.9 Тээвэрлэгчийн үүрэг

(а) Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн гэрээг төлөөлөх баримт болох тийз болон ачааны дагавар бичигт тээвэрлэлтийн гэрээний нөхцөлийг тусгасан байна. Хэрэв гэрээний нөхцөлийг бүрэн тусгаагүй бол энэ дүрэмд шаардсаны дагуу, нэмэлт мэдээллээр зорчигчдыг хангах үүрэгтэй.

(б) Тээвэрлэгч нь, өөрийн тээвэрлэлтийн нөхцөлийн талаарх мэдээллийг зорчигчийн хүсэлтээр шуудангаар болон үйлчилгээний бусад хэлбэрээр үнэ төлбөргүй илгээнэ.

(в) Тээвэрлэгч нь өөрийн тээвэрлэлтийг борлуулж буй Тийз борлуулах төв болон нисэх буудал дээр тээвэрлэлтийн гэрээний нөхцөлийн талаарх мэдээллээр зорчигчдыг хангах үүрэгтэй.

329.11 Тээвэрлэлтийн гэрээний нөхцөл

(а) Энэ дүрмийн 329.15-д зааснаас бусад нөхцөлд, тээвэрлэгч нь тээвэрлэлтийн гэрээнд дараах мэдээллийг хавсаргана:

1/ зорчигч, тухайн тээвэрлэлтийн гэрээний нөхцөлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тээвэрлэгчийн Тийз борлуулах төвөөс шаардах эрхтэй талаар;
2/ тийз борлуулах төвөөс, тээвэрлэлтийн гэрээний нөхцөлийн талаар зорчигчдод өгөх мэдээлэл нь дараах агуулгатай байна. Үүнд:

- 2.1 зорчигчдын амь нас, эд хөрөнгөд хохирол учрах, ачааг тээвэрлэх үед чанараа алдах, гэмтэх, ачаа, тээш алдагдах, хоцрох тохиолдолд тээвэрлэгчийн хүлээх хариуцлагын хязгаар;
- 2.2 тээвэрлэгч, тээвэрлэгчийн төлөөлөгчийн талаар гомдол, нэхэмжлэл гаргах нөхцөл, хугацаа;
- 2.3 тээвэрлэлтийн гэрээний нөхцөлийг өөрчлөх тээвэрлэгчийн эрхийн тухай;
- 2.4 суудал захиалгыг баталгаажуулах, бүртгэлийн хугацаа, тээвэрлэлтээс татгалзах нөхцөл, холбогдох дүрэм, зааврууд;
- 2.5 нислэгийн цагийн хуваарь, тээвэрлэгч, агаарын хөлгийн маяг, дамжин өнгөрөх нисэх буудал зэргийг өөрчлөх, нислэг саатах, цуцлах талаарх тээвэрлэгчийн эрх болон хязгаарлалт;
- 2.6 тээвэрлэлтэд хориглосон зүйлсийн талаар.

329.13 Тээвэрлэлтийн нөхцөлийн талаар мэдэгдэх

(а) Тээвэрлэгч нь, тээвэрлэлтийн гэрээнд онцлон дурдсан байвал зохих тээвэрлэлтийн нөхцөл, эсхүл тийзэнд хавсаргавал зохих тээвэрлэлтийн нөхцөлийн талаарх мэдээллийг зорчигчид хүргээгүй тохиолдолд, тийзийн төлбөрийг буцаан олгоход тавигдах хязгаарлалт, торгууль, тээвэрлэлтийн тарифыг нэмэгдүүлэх зэрэг аливаа нөхцөл тухайн зорчигчид хамаарахгүй.

329.15 Хязгаарлалт

(а) Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршиж буй Тийз борлуулах цэг нь энэ дүрмийн 329.11-д заасан мэдээллээр зорчигчийг хангаагүй нөхцөлд, зорчигч тухайн тээвэрлэгчээр тээвэрлүүлэхээс татгалзвал Тээвэрлэгч тээврийн хөлсийг аливаа торгуульгүйгээр буцаан олгоно.

(б) Тийз борлуулах цэг нь энэ дүрмийн 329.11-д заасан мэдээллээр зорчигчийг хангаагүй бол Тээвэрлэгч тухайн нислэгт зорчигчийг бүртгүүлэхээс өмнө уг мэдээллээр хангана. Хэрэв зорчигчийг уг мэдээллээр хангаагүйгээс зорчигч тухайн тээвэрлэгчээр тээвэрлүүлэхээс татгалзсан тохиолдолд Тээвэрлэгч тээврийн хөлсийг аливаа торгуульгүйгээр буцаан олгоно.

